



МХБХ-ны Зөвлөлийн
2024 оны 03 дугаар сарын 01-ний
өдрийн 02. тоот тогтоолоор батлав.



ЭЛИТ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

2024 он

АГУУЛГА

Нэг. Нийтлэг үндэслэл
Хоёр. Элит тэмцээнүүд
Гурав. Тэмцээн зохион байгуулалт
Дөрөв. Тэмцээний бүртгэл
Тав. Тэмцээний дүн гаргалт
Зургаа. Лигээс унах ба дэвших
Долоо. Тэмцээний шагнал, урамшуулал
Найм. Бусад зүйл

НЭР, ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

Дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

1. ОУХБХ – Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо;
2. АХБХ – Азийн Хөлбөмбөгийн Холбоо;
3. МХБХ – Монголын Хөлбөмбөгийн Холбоо;
4. Тогтолтын дүрэм – FIFA Laws of the Game/ FIFA Futsal Laws of the Game;
5. FIFA Connect систем – ОУХБХ-ны тоглогчдын бүртгэлийн систем;
6. FIFA TMS систем;
7. Клубын албаны хүн – Дасгалжуулагч, эмч, менежер, эзэн, захирал;
8. Элит клуб - ОУХБХ-ны “FIFA Connect” системд бүртгэлтэй АХБХ-ны клуб лицензийн журмын шалгуур үзүүлэлтийг хангасан клуб;
9. Лигийн зөвлөл – МХБХ-ны Лигийн тэмцээний зохион байгуулалт, үйл ажиллагааг хянах, шийдвэр гаргах замаар элит хөлбөмбөгийг хөгжүүлэх, сурталчлах зорилго бүхий лигийн клубүүд болон оролцогч талуудаас бүрдсэн зөвлөл.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар МХБХ-ны элит тэмцээнүүдийг зохион байгуулах үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад Элит хөлбөмбөг буюу авьяасаараа шилэгдсэн тамирчдыг элит хэмжээнд хүргэхэд чиглэсэн тэмцээнийг стандартын дагуу системтэй, тогтвортой зохион байгуулахад оршино.
- 1.3. Элит тэмцээнүүдэд /цаашид “Тэмцээн” гэнэ/ авьяастныг тодруулах, шилдгийг шалгаруулах, цааш хөгжүүлэх зарчим баримтална.

Хоёр. Элит тэмцээнүүд

- 2.1 Дараах тэмцээнүүд нь хөлбөмбөг болон футзалын элит тэмцээнд хамаарч, энэ журмын дагуу зохицуулагдана. Үүнд:

А зэрэглэл:

- 1) Нэгдүгээр Лиг
- 2) 19 хүртэлх насын лиг
- 3) Хөвгүүдийн 14, 16 насын лиг
- 4) Хөвгүүдийн 14, 16 насын цом
- 5) Хөвгүүдийн 14, 16 насын супер цом
- 6) Хөвгүүдийн 13 насын лиг /2025 оноос/
- 7) Хөвгүүдийн 15 насын лиг /2027 оноос/
- 8) Охидын 13, 15, 18 насын лиг

Б зэрэглэл:

- 9) Хөвгүүдийн 14, 16 насын АШТ
- 10) Хөвгүүдийн 13 насын АШТ /2025 оноос/
- 11) Хөвгүүдийн 15 насын АШТ /2027 оноос/
- 12) Охидын U13, U15, U18 АШТ

- 2.2 Дээр дурдагдаагүй бусад тэмцээнүүдэд энэ журам үйлчлэхгүй.

Гурав. Тэмцээний зохион байгуулалт

- 3.1. МХБХ нь хөлбөмбөг болон футзалын төрөлд элит түвшний лиг, цом, эрхийн төлөөх аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулна.

- 3.2. МХБХ-ны “Тоглогчийн шилжилт хөдөлгөөний цонх” дараах хугацаанд үргэлжилнэ. Үүнд:

- Хөлбөмбөг болон футзалын улирлын өмнөх солилцооны цонх жил бүрийн **07 дугаар сарын 04**-ний өдөр эхэлж, **08 дугаар сарын 15**-ны өдөр 17:00 цагт хаагдана.
- Хөлбөмбөг болон футзалын улирлын дундах солилцооны цонх жил бүрийн **02 дугаар сарын 01**-ний өдөр эхэлж, **02 дугаар сарын 28**-ны өдөр 17:00 цагт хаагдана.

Хэрэв солилцооны цонх хаагдах өдөр амралтын өдөр таарсан тохиолдолд дараагийн ажлын өдрийн 17:00 цагт хаагдана.

- 3.3. Элит тэмцээний тоглолтыг МХБХ-ны тоглолт зохион байгуулагчийн шалгуурыг хангасан хүн зохион байгуулна.

- 3.4. Тэмцээнд шүүгчийн шийдвэр эцсийнх байна.

- 3.5. Тэмцээнд ажиллах дасгалжуулагчийн үйл ажиллагааг “Дасгалжуулагчид тавигдах шаардлага”-аар /Хавсралт 1/ зохицуулна.

3.6. Клуб нь дасгалжуулагчтай хийсан гэрээн болон гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд тус өөрчлөлтийг Тэмцээн зохион байгуулах хэлтэст шинэчлэн бүртгүүлнэ. Гэрээгүй дасгалжуулагчийг тэмцээнд оропцуулахгүй.

3.7. Элит түвшний клуб, багууд нь "FIFA Connect" системид бүртгүүлж, клуб холбоодын зоих шалтуур үзүүлэлтүүдийг хангана.

3.8. Нэгдүгээр лигийн Тэмцээнд байнтын үйл ажиллагаатай, МХБХ-ны клуб лицензийн журмын шалтуур үзүүлэлтийг хангасан болон клуб лицензийн байгууллагаас тодорхой нөхцөл шаардлага тавьж хугацаа олгосон клубууд оролцох эрхтэй.

3.9. Хөвгүүдийн U14, U16, U19, Охидын U13, U15, U18 хуртэлх насны лигийн Тэмцээнүүдэд дээд лиг болон нэгдүгээр лигийн клубуудийн тухайн насны багууд, байнтын үйл ажиллагаатай бусад клубууд, академи /Академи гэдэг нь залуу шилдэг тоглогчийг тодруулах зорилгоор элит клуб эсвэл холбооны зүгээс байгуулсан төвийг хэлнэ/ -ууд оролцно.

3.10. Охид, хөвгүүдийн АШТ-нд байнтын үйл ажиллагаатай баг, клубууд оролцно.

3.11. Охид хөвгүүдийн Лиг, АШТ-ны тухайн жилийн улиралд клуб, багууд нь нэг багтай тохиолдолд аль нэг Тэмцээнийг сонгож оролцно. Нэээс дээш багтай тохиолдолд тус бүр нэг баг оролцуулж болно.

3.12. Элит тэмцээнд оролцох клуб, багууд нь МХБХ-ны энэхүү журам болон бусад холбогдох дурэм, журам, заавартай сайтар танилцаж, тэдгээрийн шаардлагыг зайлшигүй билеулусэн нөхцөлд тэмцээнд оролцох эрх эдэлж, Урэг хүлээнэ.

3.13. U19, U16, U14 насны лигийн Тэмцээнүүд дараах хугацаанд зохион байгуулагдана. Үүнд:

| Хүйс Нас | Тогло гүйн тоо | Талбайн хэмжээ (метр) | Хугацаа (мин) | Футзалын тогтолтын хугацаа | | | Лиг, шавьжах хугацаа | | | Футзалин Лиг шавьжах хугацаа |
|-------------|----------------------|-----------------------------|------------------|----------------------------------|--------------|-------------|----------------------|-----------|-----------------------------|------------------------------------|
| | | | | Хавар АШТ | Намар Цом | Өвөл АШТ | 1-р төрөл | 2-р төрөл | | |
| X | U14 | 11v11 | 68x105 | 80' | 15x10x15 | 5.1-10 | 10.1-10 | 1.2-2.1 | Улирлын өмнөх бэлтгэл | Улирлын өмнөх бэлтгэл |
| ӨВ | U16 | 11v11 | 68x105 | 80' | 15x10x15 | 5.1-10 | 10.1-10 | 1.2-2.1 | Улирлын өмнөх бэлтгэл | Улирлын өмнөх бэлтгэл |
| ҮД | U13 | 9v9 | Xagac | 50' | 12x8x12 | 5.1-10 | 10.1-10 | 1.2-2.1 | 8/15-10/15 | 8/15-10/15 |
| ОХИ | U15 | 11v11 | 50x70 | 70' | 15x10x15 | 5.1-10 | 10.1-10 | 1.2-2.1 | Улирлын өмнөх бэлтгэл | Улирлын өмнөх бэлтгэл |
| Д | U18 | 11v11 | 68x105 | 90' | 20x10x20 | | | | | |

Жич: Дээрх форматад тусгагдаагүй тохиолдолд Техникийн хэлтэс шийдвэрлэж Тэмцээний зааварт тусгана.

3.14. Тэмцээний зааврыг тухайн Тэмцээн эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

3.15. Элит тэмцэнд бүртгүүлсэн баг, клубын тоо 4 хүрэхгүй бол тухайн Тэмцээнийг зохион байгуулах эсэхийг Тэмцээн зохион байгуулах хэлтэс нь Техникийн хэлтэстэй зөвлөлдөж шийдвэрлэнэ.

- 3.16. Тэмцээний зөвлөгөөн болон сугалааг тэмцээн эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө зохион байгуулна.
- 3.17. Тэмцээний зөвлөгөөн нь тухайн тэмцээний сугалаа, тоглолтын хувцасны өнгө тодорхойлох болон тэмцээний заавартай холбоотой нэмэлт мэдээлэл өгөхөд оршино.
- 3.18. Тэмцээний онцлогоос хамаарч зөвлөгөөн болон сугалааг онлайн хэлбэрээр зохион байгуулж болно.
- 3.19. Тэмцээний зөвлөгөөний үеэр зааварт тусгасан заалтууд дээр ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй.
- 3.20. Тэмцээнд оролцох клубүүд МХБХ-ны “Тоглолтын хувцас, хэрэглэлийн журам” болон тоглолтын цагийн хуваарь (Хавсралт 2)-ийг дагаж мөрдөнө.
- 3.21. Тэмцээнд оролцож буй нийт клуб, тоглогчид, хөлбөмбөгийн спортыг эвсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө “FAIR PLAY” зарчмыг тэмцээний турш мөрдөх үүрэгтэй.
- 3.22. 20 хүртэлх насны тоглогч нь талбайд гарч хагас үеэс дээш хугацаанд тоглосон тохиолдолд хамгийн багадаа хоёр хоногийн дараа дараагийн тоглолтод оролцох эрхтэй.
- 3.23. Футзалын тэмцээнд 3.22 заалт үйлчлэхгүй.
- 3.24. Клубын хүсэлтийг үндэслэн тоглолтын хуваарьт өөрчлөлт оруулах тохиолдолд хамгийн багадаа 72 цагийн өмнө хамааралтай клубүүд болон бүх оролцогч талуудад мэдэгдсэн байна.
- 3.25. Насанд хүрэгчдийн тэмцээний тоглолтын талбайн хэмжээ, үргэлжлэх хугацаа “FIFA Laws of the Game”-н дүрэмд зааснаар байна.
- 3.26. Тоглогчдын тоо хөлбөмбөгийн төрөлд 7, футзалын төрөлд 3 хүрээгүй тохиолдолд тоглолтыг цуцалж, хөлбөмбөгийн төрөлд 3-0, футзалын төрөлд 5-0 гэсэн техникийн ялалт эсрэг багт олгоно.
- 3.27. Дасгалжуулагч тоглолтод ирээгүй тохиолдолд тоглолтыг цуцалж, эсрэг багт хөлбөмбөгт 3-0, футзалд 5-0 дүнгээр техникийн хожил олгоно.
- 3.28. Хөлбөмбөгийн тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежер, эмчид хамаarahгүй) болсон тохиолдолд тухайн баг нь сэлгээ хийх эрхгүйгээр тоглолтыг дуусгана.
- 3.29. Футзалын тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежер, эмчид хамаarahгүй) болсон тохиолдолд тухайн баг нь завсарлага авах эрхгүйгээр тоглолтыг дуусгана.
- 3.30. МХБХ-ны тэмцээний үеэр Тэмцээн зохион байгуулах хэлтэст хандсан хүсэлт, гомдлыг тоглолт дууссан цагаас хойш хоёр цагийн дотор зөвхөн бичгээр хүлээн авна. Тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээж авахгүй.
- 3.31. Элит лигийн тэмцээнд тоглогч эсвэл багийн албаны хүн 3 шар хуудсаар, холимог системтэй тэмцээнд 2 шар хуудсаар торгуулсан тохиолдолд дараагийн тоглолт өнжинө.
- 3.32. Тоглогч болон албаны хүн МХБХ-ны тэмцээнд сахилгын торгууль авсан тохиолдолд хугацаа харгалзахгүй бүх элит тэмцээнд хүчинтэй тооцогдоно.
- 3.33. МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс нь энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлуудыг МХБХ-ны холбогдох хороодод шилжүүлнэ. МХБХ-ны эрх зүйн баримт бичгүүдэд

тусгагдаагүй аливаа асуудлуудыг шийдвэрлэхдээ ОУХБХ болон АХБХ-ны эрх зүйн баримт бичгийг дагаж мөрднө.

Дөрөв. Тэмцээний бүртгэл

4.1 МХБХ-ны тэмцээнд гадаад болон Монгол тоглогчийг МХБХ-ны “Тоглогчийн статус ба шилжилт хөдөлгөөний журам”, “FIFA Connect” болон “FIFA TMS систем”-ийн дагуу материалыг бүрдүүлж, бүртгүүлснээр оролцуулах эрхтэй болно.

4.2 Тэмцээнд оролцох клуб нь дараах шаардлагыг хангасан мэдүүлэг /хавсралт3/ болон холбогдох бичиг баримтуудыг хавсарган зааварт тусгасан хугацаанд өгч бүртгүүлнэ. Үүнд:

- 1) Овог, нэр;
- 2) Регистрийн дугаар;
- 3) Цээж зураг /сүүлийн зургаан сарын хугацаанд авахуулсан/;
- 4) Хувийн дугаар;
- 5) Клубын баталгаат тамга, гарын үсэг;
- 6) Клубийн харилцах цахим хаяг;
- 7) Холбоо барих утасны дугаар;
- 8) Гадаад паспорт;
- 9) Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж эрүүл мэндийн хуудас/Хавсралт 4/;
- 10) Дасгалжуулагч болон тоглогч нарын клубтэй хийсэн гэрээ;
- 11) Тэмцээнд оролцох баг үндсэн /эзэн/ ба туслах /зочин/ хувцасны өнгийг хавсаргаж ирүүлнэ.

/Хавсралт 5/.

4.3. Тэмцээний мэдүүлгийг Тэмцээн зохион байгуулах хэлтсээс шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд тэмцээний зөвлөгөөнөөс өмнө бүрэн арилгуулсан байна.

4.4. Тэмцээнд оролцох багийн мэдүүлэгт бүртгүүлэх тоглогчдын тоог зааварт тусгана.

4.5. Насанд хүрэгчдийн тэмцээнд 16 насанд хүрсэн тоглогч /төрсөн сар, өдрөөр тооцно/ тоглохыг зөвшөөрнө. Төрсөн өдрийг албан ёсны бичиг баримт буюу төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх болон гадаад паспортыг үндэслэн тогтооно.

4.6. МХБХ-ны охид, хөвгүүдийн тэмцээнд оролцох тоглогчдын насыг төрсөн оноор тооцож оролцуулна. Тоглогч нэг тэмцээний хоёр өөр насны ангилалд тоглохыг зөвшөөрөхгүй ба тухайн насны баг байхгүй тохиолдолд дээд насандаа тоглож болно. Тэмцээнд насны ангиллыг доорх байдлаар ойлгоно.

Хөвгүүд:

- U16 (14-16 насны тоглогч оролцоно)
- U14 (12-14 насны тоглогч оролцоно)

Охид:

- U18 (15-18 насны тоглогч оролцоно)
- U15 (13-15 насны тоглогч оролцоно)
- U13 (11-13 насны тоглогч оролцоно)

4.7. МХБХ-ноос зохион байгуулах тэмцээний мэдүүлэгт бүртгүүлэх гадаад тоглогчдын тоонд хязгаар тавихгүй бөгөөд тухайн тэмцээнд талбайд гарах тоглогчийн тоог доорх байдлаар тусгаж өгнө. Үүнд:

- Хөлбөмбөг Нэгдүгээр лиг 3 (нэг нь заавал Ази тоглогч байна)
- Футзалын Нэгдүгээр лиг 1

4.8. МХБХ-ны бүх тэмцээнд гадаад тоглогчийг хаалгачаар бүртгүүлэхгүй.

4.9. Тэмцээний мэдүүлэгт бүртгүүлсэн хаалгач нь цаашид тоглох боломжгүй гэдэг нь нотлогдсон тохиолдолд тэмцээний хугацаанд шинэ хаалгачийг мэдүүлж болно.

4.10. МХБХ-ны Зөвлөлийн гишүүн нь давхар дасгалжуулагч болон албаны хүнээр тэмцээний мэдүүлэгт бүртгүүлэхгүй.

/Энэ заалтыг 2025 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/.

4.11. Тэмцээнд оролцох эрхийн хураамжийг зааварт заасан хугацаанд МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаана.

4.12. Тэмцээний онцлогоос хамаарч мандаттай байх эсэхийг Тэмцээн зохион байгуулах хэлтэс тухайн тэмцээний зааварт тусгана.

Тав. Тэмцээний дүн гаргалт

5.1. Тэмцээнд тоглолтын дүнг энэ зүйлд заасан аргачлал, дарааллын дагуу тооцон гаргана.

5.2. Хоёр ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна. Үүнд:

- 1) Хоорондын тоглолтын дүнгээр;
- 2) Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
- 3) Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
- 4) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
- 5) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
- 6) Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор;
- 7) Багууд талбайд байхгүй бол Fair Play оноо тодруулах зарчмаар;
- 8) Шодолтоор.

5.3. Fair Play оноо шалгаруулах үзүүлэлтийн хүснэгт:

- 1) Шар хуудас тус бүр 1 оноо,
- 2) Шууд бус улаан хуудас / 2 шар хуудас/ тус бүр 3 оноо,
- 3) Шууд улаан хуудас 3 оноо,
- 4) Шар хуудас авсны дараах шууд улаан хуудас 4 оноо.

Хамгийн бага оноотой баг нь өндөр оноотой багаасаа дээр бичигдэнэ.

5.4. Тэнцүү тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг шалгаруулахдаа хэсэг бүрийн ижил байр эзэлсэн багуудыг дараах байдлаар тодруулна. Үүнд:

- 1) Хэсгийн бүх тоглолтоос олсон оноогоор;
- 2) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
- 3) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;

- 4) Fair Play оноо тодруулах зарчмаар;
- 5) Шодолтоор.

5.5. Тэнцүү бус тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг шалгаруулахдаа, хэсгүүд дэх тоглолтын тоо тэнцүү бус учраас илүү багтай хэсгийн сүүлийн байранд орсон багтай тоглосон оноог хасаж ижил тооны тоглолттой болгож 5.4 дэх заалтаар тодруулна.

5.6. Тэмцээний дүн гаргалт болон чансаа тогтоох аргачлалтай холбоотой мэдээллийг хавсралтаар оруулав /Хавсралт 6/.

Зургаа. Лигээс унах ба дэвших

6.1. Нэгдүгээр лигт түрүүлсэн клуб Дээд лиг руу дэвшинэ.

6.2. Мэргэжлийн лигт оролцож байгаа клуб нь (А Баг), өөрийн хоёрдугаар багийг (Б Баг) Нэгдүгээр лигт оролцуулж болно. “А” болон “Б” багууд нэг тэмцээнд зэрэг оролцож болохгүй учраас “Б” баг нь нэгдүгээр лигт түрүүлвэл дэвших боломжгүй. Энэ тохиолдолд хүснэгтийн дараагийн багт тус эрхийг олгоно.

6.3. Мэргэжлийн лигийн тэмцээнээс “А” баг нь доош унаж, “Б” баг нь дээш дэвших эрх авсан тохиолдолд дэвшиж болно.

6.4. Нэгдүгээр лигийн 2-р байр эзэлсэн клуб нь дээд лигт дэвших нэмэлт тоглолт хийх бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 1) Хоёр тоглолтын нийлбэр дүнгээр ялагч баг тодорно.
- 2) Зочин багийн гоолын дүрэм үйлчлэхгүй. Бөмбөгний зөрүүгээр ялагч баг тодорно.
- 3) Хэрэв хоёр тоглолтын дараа 2 багийн бөмбөгний харьцаа тэнцсэн тохиолдолд нэмэлт цаг сунгана.
- 4) Хэрэв нэмэлт цагт ялагч тодрохгүй тохиолдолд торгуулийн цохилтоор ялагч багийг тодруулна.
- 5) Нэмэлт тоглолтын үед багууд тус бүр нэг удаа эзэн багаар тоглоно.

6.5. Дээд лигийн улирал эхлэхээс өмнө, нэгдүгээр лигээс дэвшин орох эрхтэй клуб нь тодорхой шалтгааны улмаас оролцох боломжгүй тохиолдолд Тэмцээн Зохион Байгуулах Хороо болон Техник Хөгжлийн Хорооны саналыг үндэслэж МХБХ-ны Зөвлөл хэрхэн нөхөн оролцуулах талаар шийдвэр гаргана.

6.6. Нэгдүгээр лигийн тэмцээнээс МХБХ-ны клуб лицензжуулэх журмын шалгуур үзүүлэлтийг хангаагүй, клуб лицензжуулэх байгууллагаас тодорхой хугацаанд тавьсан нөхцөл шаардлагыг биелүүлээгүй клубүүд хасагдана.

Долоо. Тэмцээний шагнал урамшуулал

7.1. Тэмцээнд шилдэг багуудыг шалгаруулж, багт өргөмжлөл, тоглогчдод батламж, медаль, мөнгөн шагнал олгоно.

7.2. Тухайн тэмцээний шагнал, урамшуулал, медалийн тоо, шилдгүүдийг шалгаруулах эсэхийг тэмцээний зааварт нарийвчлан тусгана.

7.3. Тэмцээнд оролцож байгаа багийн тооноос хамаарч хэдэн баг шагнахыг Тэмцээн зохион байгуулах хэлтэс шийдвэрлэнэ.

7.4. Монгол Улсын хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу нийт шагналын сангийн 5 хувийг суутган тооцож, татварын байгууллагад шилжүүлнэ.

Найм. Бусад зүйл

8.1 Клубын дасгалжуулагч, менежер, багийн ахлагч, эмч зэрэг албаны хүмүүс нь өөрийн ажил, үүргээ ухамсарлаж хариуцлага хүлээх чадвартай байна. Албаны хүн нь давхар үүрэг гүйцэтгэхгүй. /жишээ нь багийн менежер дасгалжуулагчийн үүргийг гүйцэтгэхгүй/.

8.2 Өсвөр үе, хүүхдийн багийн бүх тэмцээнд оролцогч талууд МХБХ-ны хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг баг, клубуудаас шаардана.

8.3 Нэгдүгээр лигийн клубууд тоглолтод оролцохдоо өөрийн эмчтэй оролцно. Эмчгүй тохиолдолд клубыг 300,000 төгрөгөөр торгоно. Бусад элит тэмцээнүүдэд эмчтэй оролцох эсэхийг тэмцээний зааварт тусгана.

8.4 Элит лигийн тоглолтод ахлах дасгалжуулагч эсвэл туслах дасгалжуулагчгүй оролцсон зөрчил гаргасан тохиолдолд тухайн багийг 200,000 төгрөгөөр торгоно. Тус торгуулийг тэмцээний дараагийн тоглолтоос өмнө заавал төлсөн байна. Хэрэв тус баг нь хоёр дахь удаа дээрх зөрчлийг гаргасан тохиолдолд 400,000 төгрөг, харин гурав дахь удаа давтан үйлдсэн тохиолдолд 600,000 төгрөг болон -3 оноогоор шийтгэнэ.

8.5 Хэвлэл мэдээлэл болон маркетингийн үйл ажиллагаа нь "МХБХ-ны Цэнгэлдэх Хүрээлэнгийн Журам"-аар нарийвчлан зохицуулагдана.

8.6 Тэмцээнтэй холбоотой үссэн сахилгын болон ёс зүйн аливаа асуудал нь МХБХ-ны Сахилгын дүрэм, Ёс зүйн дүрмийн дагуу зохицуулагдана.

8.7 Энэхүү журамд дараах хавсралтууд багтсан болно. Үүнд:

- 1) ТЗБЖ Хавсралт 1 Дасгалжуулагчид тавигдах шаардлага;
- 2) ТЗБЖ Хавсралт 2 Тэмцээнд мөрдөх албан ёсны цаг;
- 3) ТЗБЖ Хавсралт 3 Тэмцээний мэдүүлэг;
- 4) ТЗБЖ Хавсралт 4 Эрүүл мэндийн хуудас;
- 5) ТЗБЖ Хавсралт 5 Хувцасны өнгө;
- 6) ТЗБЖ **Хавсралт 6** Дүн гаргалт болон чансаа тогтоох аргачлал.

8.8 Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа санал гаргах эрх бүхий субъектээс албан бичгээр хүлээн авч дараах үе шатаар дамжуулан шийдвэрлэнэ. Үүнд:

- 1) Албан бичгийг Тэмцээн Зохион Байгуулах хэлтэс хүлээн авна.
- 2) Техникийн хэлтэст шилжүүлэн саналыг авна.
- 3) Техник Хөгжлийн Хороо, Тэмцээн Зохион Байгуулах Хороо хамтран хэлэлцэж шийдвэр гаргана.
- 4) Зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлагдана.

8.9 Тус журам нь батлагдсан өдрөөс хучин төгөлдөр болох бөгөөд 2024 онд шинээр эхлэх тэмцээнүүдээс эхлэн хэрэгжинэ.

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО



ТЭМЦЭЭНД АЖИЛЛАХ ДАСГАЛЖУУЛАГЧИЙН ШААРДЛАГА

1. Тэмцээнд клуб нь ахлах, туслах, хаалгачийн дасгалжуулагчтай оролцохыг шаардана.
2. Зөвхөн хаалгач нь хаалгачийн дасгалжуулагчаар багийн мэдүүлэгт давхар бүртгүүлж болно.
3. Клуб нь 2025-2026 оны улирлаас эхэлж фитнесс дасгалжуулагчтай оролцоно.
4. Тэмцээнд элит дасгалжуулагч ажиллах бөгөөд бусад тэмцээнд дасгалжуулагчаар давхар ажиллаж болох эсэхийг “АХБХ-ны Дасгалжуулагчийн Конвенцийн Журам”-ыг үндэслэн Техникийн хэлтэс шийдвэрлэнэ.
5. МХБХ-ны Техникийн хэлтэс нь тоглолтод оролцох дасгалжуулагчийн лицензийг олгох, шалгах, сануулах, түдгэлзүүлэх арга хэмжээг авах эрхтэй.
6. Элит тэмцээнүүдэд дасгалжуулагч нь дараах шаардлагыг хангасан хүчин төгөлдөр лицензтэй байна. Үүнд:

| № | Ажиллах баг | Ахлах дасгалжуулагч | Туслах дасгалжуулагч | Хаалгачийн дасгалжуулагч |
|---|--------------------------------|--------------------------------------|--------------------------------------|-----------------------------------|
| 1 | Талбайн 1-р Лиг | АХБХ “В” ба түүнээс дээш | АХБХ “С” ба түүнээс дээш | АХБХ Хаалгач “1” 2024-2025 он |
| 2 | Футзалын 1-р Лиг | АХБХ-ны 1-р зэрэглэл ба түүнээс дээш | МХБХ-ны 1-р зэрэглэл ба түүнээс дээш | АХБХ Футзалын хаалгач “1” 2026 он |
| 3 | U19, U16, U14 Лиг/АШТ | AFC “C” ба түүнээс дээш | МХБХ “С” ба түүнээс дээш | АХБХ Хаалгач “1” 2025 он |
| 4 | Футзалын U19, U16, U14 Лиг/АШТ | МХБХ-ны 1-р зэрэглэл ба түүнээс дээш | МХБХ-ны 1-р зэрэглэл ба түүнээс дээш | АХБХ Футзалын хаалгач “1” 2026 он |

7. МХБХ-ны талбайн тэмцээнүүдэд ажиллах гадаад дасгалжуулагч хамгийн багадаа АХБХ-ны “А” болон түүнээс дээш зэрэглэлтэй, АХБХ-ны “А” болон түүнээс дээш зэрэглэлтэй дүйцэхүйц дасгалжуулагчийн лицензтэй байна. МХБХ-ны футзалын тэмцээнд ажиллах гадаад дасгалжуулагч нь “АХБХ-ны 2”-р зэрэглэл болон түүнээс дээш зэрэглэлтэй, “АХБХ-ны 2”-р зэрэглэл болон түүнээс дээш зэрэглэлтэй дүйцэхүйц дасгалжуулагчийн лицензтэй байна.
8. Дасгалжуулагчийн хэн нэг нь тоглолтод оролцох боломжгүй тохиолдолд тухайн клуб нь хамгийн багадаа тоглолтоос 24 цагийн өмнө МХБХ-ны Техникийн хэлтэс болон Тэмцээн зохион байгуулах хэлтэст албан хүсэлт илгээсэн байна. Техникийн хэлтэс тус тайлбарыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд дасгалжуулагчийг тоглолтоос чөлөөлж болно. Харин түүний оронд тус клуб нь өсвөрийн багаасаа лицензтэй туслах дасгалжуулагчийг ажиллуулна.



Албан ёсны мөрдөх цаг /Жишиг загвар/

| Тогтолт | | ҮНДЭСНИЙ НЭГДҮГЭЭР ЛИГ | |
|---------|------|------------------------|-------|
| A Баг | | Б баг | |
| Стадион | МХБХ | Тогтолтын дугаар | |
| Огноо | | Цаг | 10:00 |

| Мөрдөх цаг | Үйл ажиллагааны дараалал | Цаг |
|------------|--|-------|
| - 02:00' | Хянагч шүүгч болон шүүгч нар талбайд ирэх | 08:00 |
| - 01:30' | Багууд тогтолт болох газар ирсэн байна | 08:30 |
| - 01:20' | Мандат хувцасны шалгалт | 08:40 |
| - 01:10' | Тогтолтын гарааны жагсаалтыг бэлэн болгож тараах | 08:50 |
| - 50' | Тоглогчид, хаалгачид бие халаалтанд гарах | 09:10 |
| - 30' | Гарааны бүрэлдэхүүнийг зарлах | 09:30 |
| - 20' | Бие халаалт дуусах | 09:40 |
| - 10' | Албаны хүмүүс болон сэлгээний тоглогчид гарах | 09:50 |
| - 8' | Гарааны тоглогчид коридорт бэлэн байх | 09:52 |
| - 7' | Шүүгчийн шалгалт | 09:53 |
| - 4' | Шүүгч нар болон тоглогчид талбайд гарах | 09:56 |
| - 3' | Тоглогчид зураг авуулах, шодох | 09:57 |
| - 0' | Тогтолт эхлэх | 10:00 |



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Лого



"....." КЛУБЫН МЭДҮҮЛЭГ.

ХУУДАС

1

ТЭМЦЭЭН

/ ТЭМЦЭЭНИЙ НЭР/

ТОГЛОГЧДЫН МЭДҮҮЛЭГ

| |
|--|
| СУУЛИЙН З САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ |
|--|

ОВОГ
НЭР
ГАДААД ПАССПОРТ
РЕГИСТРЫН ДУТААР
ТӨРСӨН ОН САР ӨДӨР
ХУВИЙН ДУТААР

| |
|---------|
| андар |
| жин |
| БАЙРЛАЛ |

| |
|--|
| СУУЛИЙН З САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ |
|--|

ОВОГ
НЭР
ГАДААД ПАССПОРТ
РЕГИСТРЫН ДУТААР
ТӨРСӨН ОН САР ӨДӨР
ХУВИЙН ДУТААР

| |
|---------|
| андар |
| жин |
| БАЙРЛАЛ |

| |
|--|
| СУУЛИЙН З САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ |
|--|

ОВОГ
НЭР
ГАДААД ПАССПОРТ
РЕГИСТРЫН ДУТААР
ТӨРСӨН ОН САР ӨДӨР
ХУВИЙН ДУТААР

| |
|---------|
| андар |
| жин |
| БАЙРЛАЛ |

| |
|--|
| СУУЛИЙН З САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ |
|--|

ОВОГ
НЭР
ГАДААД ПАССПОРТ
РЕГИСТРЫН ДУТААР
ТӨРСӨН ОН САР ӨДӨР
ХУВИЙН ДУТААР

| |
|---------|
| андар |
| жин |
| БАЙРЛАЛ |

| |
|--|
| |
|--|

ОВОГ
НЭР
ГАДААД ПАССПОРТ

| |
|--|
| |
|--|

Page 1



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

| № | ТОГЛОГЧИЙН НЭРС | ҮЗЛЭГТ ОРСОН ОГНОО | ЭМЧИЙН ТЭМДЭГЛЭЛ | ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛД ХАМРАГДСАН ЭСЭХ | |
|----|-----------------|-----------------------|------------------|--|------|
| | | | | ТҮЙМ | ҮГҮЙ |
| 1 | | | | | |
| 2 | | | | | |
| 3 | | | | | |
| 4 | | | | | |
| 5 | | | | | |
| 6 | | | | | |
| 7 | | | | | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| 10 | | | | | |
| 11 | | | | | |
| 12 | | | | | |
| 13 | | | | | |
| 14 | | | | | |
| 15 | | | | | |
| 16 | | | | | |
| 17 | | | | | |
| 18 | | | | | |
| 19 | | | | | |
| 20 | | | | | |
| 21 | | | | | |



**МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО
ТЭМЦЭЭНИЙ НЭР:**

ХУВЦАСНЫ ӨНГЕ


ОРОЛЦОГЧ БАГ:

ХУВЦАСНЫ ӨНГИЙГ БИЧИК БОЛОН БУДАЖ ӨГНӨ УУ.

ЧАДСАН ӨМСГӨЛ

ТАЛВАЙН ТӨГЛӨГЧ


НОРЦ ӨМСГӨЛ



өмсгөл

ШОРТ

ОФМС



ХААЛГАЧ



өмсгөл

ШОРТ

ОФМС



ДООРХИ ХУГАЦЛЫАС СИНЮ ТЭБХӨЛТӨСТ ӨГНӨ УУ.



Хавсралт 6

Дүн гаргалт болон Чансаа тогтоох аргачлал

1. МХБХ-ны тэмцээнд хэсгийн тоглолтын болон хасагдах шатны дүнг энэ зүйлд заасан аргачлал, дарааллын дагуу тооцон гаргана.
 - a) Fair Play оноо шалгаруулах үзүүлэлтийн хүснэгт;
 - b) Шар хуудас тус бүр 1 оноо,
 - c) Шууд бус улаан хуудас / 2 шар хуудас/ тус бүр 3 оноо,
 - d) Шууд улаан хуудас 3 оноо,
 - e) Шар хуудас авсны дараах шууд улаан хуудас 4 оноо.

Хамгийн бага оноотой баг нь өндөр оноотой багаасаа дээр бичигдэнэ.
2. Хоёр ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна. Үүнд:
 - a) Хоорондын тоглолтын дүнгээр;
 - b) Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
 - c) Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
 - d) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
 - e) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
 - f) Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор;
 - g) Багууд талбайд байхгүй бол Fair Play оноо тодруулах зарчмаар;
 - h) Шодолтоор.
3. Тэгш тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг шалгаруулахад хэсэг бүрийн хүснэгтийн 2-т буй сайн үзүүлэлттэй багуудыг дараах байдлаар тодруулна. /Хүснэгтийн 2-т байгаа багийг жишээ болгов/. Үүнд:
 - a) Хэсгийн бүх тоглолтоос олсон оноогоор;
 - b) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
 - c) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
 - d) Fair Play оноо тодруулах зарчмаар;
 - e) Шодолтоор.

Тайлбар:

А Хэсэг

| Баг | Тоглолт | Хожил | Тэнцүү | Хожигдол | ОБ | АБ | БЗ | Оноо |
|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| А баг | 3 | 2 | 1 | 0 | 3 | 0 | 3 | 7 |
| В баг | 3 | 2 | 0 | 1 | 6 | 3 | 3 | 6 |
| С баг | 3 | 0 | 2 | 1 | 0 | 3 | -3 | 2 |
| D баг | 3 | 0 | 1 | 2 | 2 | 5 | -3 | 1 |

Б Хэсэг

| Баг | Тоглолт | Хожил | Тэнцүү | Хожигдол | ОБ | АБ | БЗ | Оноо |
|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| E баг | 3 | 3 | 0 | 0 | 4 | 0 | 4 | 9 |
| F баг | 3 | 2 | 0 | 1 | 5 | 3 | 2 | 6 |
| G баг | 3 | 1 | 0 | 2 | 4 | 4 | 0 | 3 |
| H баг | 3 | 0 | 0 | 3 | 1 | 7 | -6 | 0 |

Дээрх хүснэгтийн дагуу **B** болон **F** багууд хүснэгтүүдийн 2-т бичигдэж байна.

B болон **F** багууд нь тус бүр 6 оноотой. Иймд (1) заалтаар бол 2 баг ижил 6 оноотой тул (2) заалтын /хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр/ дагуу **B баг +3** гоолын зөрөөтэй бол **F баг +2** гоолын зөрөөтэй тул **B баг** хамгийн сайн үзүүлэлттэй 2-т бичигдэх багаар тодорно.

4. **Тэгш бус тооны багуудтай хэсгүүдээс хамгийн сайн үзүүлэлттэй багийг дараах байдлаар шалгаруулна. /Хүснэгтийн 2-т байгаа багийг жишээ болгов/. Хэсгүүдэд тэгш бус тооны багууд орсон тохиолдолд тоглолтын тоо тэгш бус байна. Иймд хамгийн сайн үзүүлэлттэй багийг тодруулахын тулд багууд ижил тооны тоглолт хийсэн байх шаардлагатай.**

Дээрх тохиолдолд илүү багтай хэсгийн хамааралтай баг болон сүүлийн багийн тоглолтыг тэглэнэ. Хэсэг бүрийн 2-т байх сайн үзүүлэлттэй багуудыг дараах байдлаар тодруулна. Үүнд:

- a) Хэсгийн бүх тоглолтоос олсон оноогоор;
- b) Хэсгийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр;
- c) Хэсгийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр;
- d) Fair Play оноо тодруулах зарчмаар;
- e) Шодолтоор

Тайлбар:

A Хэсэг

| Баг | Тоглолт | Хожил | Тэнцүү | Хожигдол | ОБ | АБ | БЗ | Оноо |
|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| A баг | 3 | 2 | 1 | 0 | 3 | 0 | 3 | 7 |
| B баг | 3 | 2 | 0 | 1 | 6 | 3 | 3 | 6 |
| C баг | 3 | 0 | 2 | 1 | 0 | 3 | -3 | 2 |
| D баг | 3 | 0 | 1 | 2 | 2 | 5 | -3 | 1 |

B Хэсэг

| Баг | Тоглолт | Хожил | Тэнцүү | Хожигдол | ОБ | АБ | БЗ | Оноо |
|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| E баг | 4 | 3 | 1 | 0 | 14 | 1 | 13 | 10 |
| F баг | 4 | 3 | 0 | 1 | 5 | 2 | 3 | 9 |
| G баг | 4 | 1 | 2 | 1 | 5 | 5 | 0 | 5 |
| H баг | 4 | 0 | 2 | 2 | 2 | 9 | -7 | 2 |
| I баг | 4 | 0 | 1 | 3 | 2 | 11 | -9 | 1 |

Дээрх хүснэгтийн дагуу **B** болон **F** багууд хүснэгтүүдийн 2-т бичигдэж байна.

Хамгийн сайн үзүүлэлттэй багийг тодруулахын тулд хэсгийн багуудын тоог тэнцүүлж тус бүр 4 багтай болгоно. Иймд **B** хэсгийн **F** болон **I** багуудын тоглолтыг тэглэнэ.

Жишээ нь **F** баг **I** багийг 3:0 харьцаатайгаар хожсонд тооцоод **F** багаас 3 оноо болон 3 гол хасагдаж дараах байдлаар **F** багийн шинэчлэгдсэн хүснэгт гарна.

| Баг | Тоглолт | Хожил | Тэнцүү | Хожигдол | ОБ | АБ | БЗ | Оноо |
|--------------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|
| E баг | 4 | 3 | 1 | 0 | 14 | 1 | 13 | 10 |
| F баг | 3 | 2 | 0 | 1 | 2 | 2 | 0 | 6 |
| G баг | 4 | 1 | 2 | 1 | 5 | 5 | 0 | 5 |
| H баг | 4 | 0 | 2 | 2 | 2 | 9 | -7 | 2 |
| I баг | 0 | 0 | 1 | 3 | 2 | 11 | -9 | 0 |

Эцсийн байдлаар В баг болон F багуудын тооцолол дараах байдлаар гарах ба хамгийн сайн үзүүлэлттэй 2-р байрын багаар В баг +3 гоолийн зөрүүгээр дараагийн шатанд шалгарна.

| | | | | | | | | |
|--------------|---|---|---|---|---|---|---|---|
| В баг | 3 | 2 | 0 | 1 | 6 | 3 | 3 | 6 |
| F баг | 2 | 2 | 0 | 1 | 2 | 2 | 0 | 6 |

5. Хасагдах шатны тоглолтын дүн тэнцсэн тохиолдолд:

Нэг тоглолттой үед:

- 1) Нэмэлт цаг (Тэмцээний онлцогоос хамаарч нэмэлт цаггүй байж болно);
- 2) 11 метрийн торгуулийн цохилтоор шийдвэрлэнэ.

Хоёр тоглолттой үед:

- 3) Бөмбөгний харьцаа;
- 4) Нэмэлт цаг (Тэмцээний онлцогоос хамаарч нэмэлт цаггүй байж болно);
- 5) 11 метрийн торгуулийн цохилтоор шийдвэрлэнэ.

ЧАНСАА ТОГТООХ АРГАЧЛАЛ ДРАФТ.

1. МХБХ нь 2023/2024 оны улирлаас эхэлж Улсын Аварга Шалгаруулах Тэмцээн болон Лигийн тэмцээн зохион байгуулагдсаны дараагаар багуудыг чансаагаар эрэмбэлнэ.

1.1 УАШТ-ий хүрээнд зөвхөн хасагдах шатанд шалгарсан 1–16 хүртэлх байруудын багуудыг эрэмбэлнэ.

1.2 Лигийн тэмцээний хүрээнд тухайн зааварт тусгасан багийн тоогоор тэмцээний төгсгөлд хүснэгтийн дагуу эрэмбэлэгдэнэ.

2. Лигт оролцсон багуудын чансааг дараах байдлаар тогтооно. Үүнд:

2.1 Лигийн хүрээнд зохион байгуулагдсан бүх тоглолтын төгсгөлд тэмцээний хүснэгтэд эзэлсэн байрын дагуу эрэмбэлэгдсэн гэж үзнэ.

3. Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон багуудын эрэмбийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

3.1 Улсын Аварга Шалгаруулах Тэмцээний хасагдах шатны ижил даваанд өрсөлдөж буй багуудын чансааг доорх байдлаар тодруулна.

| ЧАНСАА | АРГАЧЛАЛЫГ ДЭЛГЭРЭНГҮЙ БАЙДЛААР |
|--------|--|
| 1 | Тэмцээний аварга баг нь чансааны нэг дүгээр байранд эрэмбэлэгдэнэ. |
| 2 | Тэмцээний шигшээ тоглолтод ялагдсан баг нь хоёр дугаар байранд эрэмбэлэгдэнэ |
| 3 – 4 | <p>Тэмцээний хүрэл медаль хүртсэн баг нь гурав дугаар байранд эрэмбэлэгдэх ба, тус тоглолтод ялагдал хүлээсэн баг нь дөрөвдүгээр байранд эрэмбэлэгдэнэ.</p> <p>(Зөвхөн МХБХ-ны Цом тэмцээний хагас шигшээд хожигдсон хоёр багууд нь ижил 3-4 дүгээр байранд эрэмбэлэгдэнэ)</p> <p>Хэрэв 3-4 дүгээр байрны тоглолтууд зохион байгуулагдахгүй тохиолдолд, хагас шигшээ шатанд хожигдол авсан багууд дараах байдлаар эрэмбэлэгдэнэ:</p> |

| | |
|---------------|--|
| | <ol style="list-style-type: none"> 1. Хагас шигшээ шатанд оруулсан бөмбөгний зөрүүгээр; 2. Хагас шигшээ шатанд оруулсан гоолын ихээр; 3. Шөвгийн наймд оруулсан бөмбөгний зөрүүгээр (боломжтой бол); 4. Шөвгийн наймд оруулсан гоолын ихээр; 5. Шөвгийн арван зургаа шатанд бөмбөгний зөрүүгээр (боломжтой бол); 6. Шөвгийн арван зургаа шатанд оруулсан гоолын ихээр (боломжтой бол); 7. Энэ журмын "Хавсралт 6"-ын 3 болон 4 дэх заалтуудыг баримтална. |
| 5 - 8 | <p>Зөвхөн шөвгийн наймын тоглолтуудад хожигдол хүлээсэн багууд 5–8 дугаар байрыг эзэлнэ. Тус чансааны багуудыг дараах байдлаар эрэмбэлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шөвгийн найм шатанд оруулсан бөмбөгний зөрүүгээр; 2. Шөвгийн найм шатанд оруулсан гоолын ихээр; 3. Шөвгийн арван зургаад оруулсан бөмбөгний зөрүүгээр (боломжтой бол); 4. Шөвгийн арван зургаад оруулсан гоолын ихээр; 5. Энэ журмын "Хавсралт 6"-ын 3 болон 4 дэх заалтуудыг баримтална. |
| 9 - 16 | <p>Зөвхөн шөвгийн арван зургаа дугаар шатанд хожигдол хүлээсэн багууд 9–16 дугаар байрыг эзэлнэ. Тус чансааны багуудыг дараах байдлаар эрэмбэлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шөвгийн арван зургаа дугаар шатанд оруулсан бөмбөгний зөрүүгээр; 2. Шөвгийн арван зургаа дугаар шатанд оруулсан гоолын ихээр; 3. Энэ журмын "Хавсралт 6"-ын 3 болон 4 дэх заалтуудыг баримтална. |

Тэмдэглэл*

Хасагдах шатны тоглолтод хожигдсон тохиолдолд дараах байдлаар эрэмбэлнэ. Үүнд:

1. Үндсэн цагийн үр дүнгээр эрэмбэлнэ.
2. Хэрэв нэмэлт цаг сунгах заавартай тэмцээн бол "Extra Time"-ын үр дүнгээр эрэмбэлнэ.
3. Хэрэв 1 болон 2 дугаар заалтуудад тэнцсэн хэвээр байх тохиолдолд чансаа тогтоох эрэмбийн аргачлалаар бодно.

Жишээ 1: (Үндсэн цагт тэнцсэн тохиолдолд)

| ШӨВГИЙН 8-ИЙН ЭРЭМБЭ | | | X/Г | A/Г | B/З |
|-----------------------------|--------------|---|-----|-----|-----|
| 5 | А БАГ | 4-5 харьцаатайгаар Торгуулийн цохилтоор хожигдсон (үндсэн цагт 0-0, 1-1 тэнцэж/ 1-1 нэмэлт цагт тэнцсэн) | 1 | 1 | 0 |
| 6 | Б БАГ | 1-3 харьцатайгаар нэмэлт цагт хожигдсон (0-0 ,1-1) | 1 | 3 | -2 |
| 7 | В БАГ | Үндсэн цагт 0-1 харьцаатайгаар хожигдсон | 0 | 1 | -1 |
| 8 | Г БАГ | Үндсэн цагт 0-2 харьцаатайгаар хожигдсон | 0 | 2 | -2 |

Жишээ 2: ("Extra-Time" -ын үр дүн тэнцсэн тохиолдолд)

| ШӨВГИЙН 8-ИЙН ЭРЭМБЭ | | | X/Г | A/Г | B/З |
|-----------------------------|--------------|---|-----|-----|-----|
| 5 | А БАГ | 4-5 харьцаатайгаар Торгуулийн цохилтоор хожигдсон (үндсэн цагт 0-0, 1-1 тэнцэж/ 1-1 нэмэлт цагт тэнцсэн) | 1 | 1 | 0 |
| 6 | Б БАГ | 1-3 харьцаатайгаар нэмэлт цагт хожигдсон (0-0 ,1-1) | 1 | 3 | -2 |
| 7 | В БАГ | Үндсэн цагт 0-1 харьцаатайгаар хожигдсон | 0 | 1 | -1 |
| 8 | Г БАГ | Үндсэн цагт 0-2 харьцаатайгаар хожигдсон | 0 | 2 | -2 |